



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 0/370

Арвайхээр

### Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Н.Болдбаатарыг төрийн албанаас чөлөөлөх тухай" 2020 оны Б/35 дугаар тушаалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Онги-Таац голын сав газрын захиргааны дарга Нямдоржийн Болдбаатарын үүрэгт ажлыг 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хүлээлцүүлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Энхцэцэг –аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга  
Гишүүд: Ц.Удвал - аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Б.Ганчимэг -Онги-Таац голын сав газрын захиргааны нягтлан бодогч  
Ш.Дуламжаргал -Онги-Таац голын сав газрын захиргааны Усны нөөцийн нэгдсэн менежмент, олон нийт, сургалт, архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн

3. Ажил хүлээлцсэн акт болон холбогдох баримт материалыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэг (Н.Энхцэцэгт)-т үүрэг болгосугай.



ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН

011100825